

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧИМНІХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ..... ЦАМАРСАНАА-



ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧ:
“БАРИЛГА БАЙГУУЛАМЖ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ..... Ч.НАРАНДЭЛГЭР



БАРИЛГЫН АЖИЛД ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧИЙН
ХЯНАЛТ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2021 оны 02 сарын 01 өдөр.

Дугаар: 5-2021/02

Улаанбаатар хот.

Нэг. Гэрээний ерөнхий нөхцөл

1.1 Энэхүү гэрээг нэг талаас захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч Барилгын хөгжлийн төв ТӨҮГ /цаашид “Төв” гэх/, нөгөө талаас 3Т48-205/17 дугаартай зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй зураг төсөл зохиогч “Барилга байгууламж” ХХК /цаашид “зохиогч” гэх/ нар Соёлын төвийн барилга, 150 суудал /Говь-Алтай, Бугат сум/-н барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгэх тухай харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

1.2 Монгол Улсын “Иргэний хууль”, “Барилгын тухай” хууль болон “Хот байгуулалтын тухай” хууль, “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм /БНБД 11-04-16/-ийн дагуу барилгын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгүүлэхтэй холбогдон гарах үүрэг, хариуцлагыг тогтоох, зохиогчийн хяналт хийх тоо, хугацаа, ажлын чанар, шаардагдах зардлын хэмжээг эцэслэн тохирч хэрэгжүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

1.3 Зохиогчийн хяналт нь эрх бүхий холбогдох байгууллагуудтай зөвшилцэж хянаж баталгаажуулсан магадлалын дүгнэлттэй барилгын зураг төсөл техникийн баримт бичгийг үндэслэл болгоно.

1.4 Барилгын захиалагч Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Аксу-Алтай ХХК-тай байгуулсан барилга угсралтын ажлын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн ТӨБЗГ-2019/XII.2.1.52 дугаартай гэрээнд тусгагдсан зохиогчийн хяналтын зардал нийт 12,813,700 /арван хоёр сая найман зуун арван турван мянга долоон зуу/ төгрөгт багтаан 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгөх өдөр хүртэл хугацаанд зохиогчийн хяналтыг хийж гүйцэтгэхээр тохиролцов.

Хоёр. Гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг

2.1. Гэрээ байгуулагч Төв, зохиогч нар тухайн барилга угсралтын ажилд хяналт тавьж ажиллах инженерүүдийг өөрийн байгууллагын захирлын тушаалаар албан ёсоор томилно.

2.2 Төв, зохиогч нар зөвшилцэн барилгын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, санхүүжилтийн зардлын тооцоог боловсруулж баталгаажуулна.

2.3 Төв нь зохиогчийн хяналт тавих гэрээнд тусгагдсан ажлын хүрээнд тухайн барилга, байгууламжтай холбоотой шаардлагатай мэдээллийг “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм /БНБД 11-04-16/-ийн хавсралт 1 хүснэгтийн 1-4-д заасны дагуу зохиогчид гаргаж өгнө. /барилгын үндсэн хийц бүтээц, тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ, туршилтын үр дүн, агаарын бохирдолтын байдал, гүйцэтгэх хугацаа, мэдээлэл гэх мэт/

2.4 Гэрээт талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ орхигдуулж, биелүүлээгүйгээс үүссэн хохирлыг өөрөө бүрэн хариуцаж, хохирлыг барагдуулна.

2.6 Талуудын хооронд үүссэн гомдол, нэхэмжлэлийн маргаантай асуудлыг харилцан хүндэтгэх, хамтын ажиллагааны үзэл санааг баримтлан хэлэлцээрийн замаар шийдвэрлэх бөгөөд, маргааныг эв зэээр шийдвэрлэж чадахгүй нөхцөлд шүүхийн байгууллагад хандан холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

2.7 Гэрээ байгуулагч талуудаас шуудан, факс, цахим хаягаар илгээсэн баримт бичиг эрх бүхий хүмүүсийн гарын үсэг, электрон тоон буюу аналогиор баталгаажсан байвал уг баримт бичгийг энэхүү гэрээний 2.6-д заасан маргааныг шийдвэрлэхэд баталгаа болгон ашиглах эрхтэй.

2.8 Гэрээнд тусгагдсан ажлын зураг төсөл болон хийц бүтээц, эдлэхүүн, материал өөрчлөх тухай аливаа санал гаргаж хэрэгжүүлэх этгээд эдгээртэй холбогдон гарах санхүүжилтийн зардлыг хариуцна.

2.9 Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт гүйцэтгэх гэрээг байгуулж чиг үүргийг хэрэгжүүлээгүй бол холбогдох буруутай хуулийн этгээд хариуцлага хүлээнэ.

Гурав. Төвийн эрх, үүрэг

3.1 Төв нь зохиогчоос ирүүлсэн албан бичиг, хурлын протоколд тэмдэглэгдэж баталгаажсан аливаа асуудалд тухай бүр албан бичгээр хариу өгнө.

3.2 Төв нь барилгын ажлыг батлагдсан зураг төслөөс өөрчилж гүйцэтгэсэн зөрчил илэрсэн тохиолдолд бүрд зохиогчид энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ.

3.3 Төв нь энэхүү гэрээнд тусгагдаагүй зохиочийн хяналт зайлшгүй тавих нэмэлт ажил, холбогдох зардлын талаарх мэдээллийг захиалагчид хүргүүлж шийдвэрлүүлнэ.

3.4 Төв нь гэрээний хүрээнд зохиогчийн хяналт гүйцэтгэхтэй холбоотой гаргасан тайлан, баримт бичиг, бусад материалуудыг зохиогчоос шаардах эрхтэй.

3.5 Төв нь эрх бүхий хуулийн этгээдтэй зохиогчийн хяналтын гэрээг байгуулж хэрэгжилтийг хангулна.

3.6 Төв нь зохиогч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна гэж үзвэл холбогдох дүгнэлт гаргаж гэрээг цуцалж Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад зохиогчийн хяналт гүйцэтгэх эрхийг шилжүүлэх хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

3.7 Төвөөс үл хамаарах шалтгаанаар барилгын ажил хугацаа хойшлох буюу бүрэн зогсоход хүрвэл гэрээг сунгах, цуцлах асуудлыг шийдвэрлэх эрхтэй. Төв барилгын ажлыг цуцлах саналыг зохиогчид 30 хоногийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

3.8 Төв нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол тус төвийн холбогдох буруутай этгээд гарсан хохирлыг хариуцна.

3.9 Барилгын ажилд батлагдсан зураг төслийн баримт бичгийг мөрдөөгүй, барилга угсралтын ажил, тоног төхөөрөмжийн суурилуулалтад барилгын норм ба дүрэм, стандартын шаардлага, технологийн горим, техникийн нөхцөл зөрчсөн зөрчил, доголдлын талаар зохиогчоос гаргасан дүгнэлт, шийдвэрийг Төв нь холбогдох буруутай этгээдээр арилгуулах үүрэгтэй.

3.10 Төв нь Зохиогчоос тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй. Уг шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүйгээс гарах хохирлыг Төв хариуцна.

Дөрөв. Зохиогчийн эрх, үүрэг

4.1. Зохиогч нь гэрээнд тусгагдсан барилгын ажилд батлагдсан зураг төсөл, барилга үйлдвэрлэлийн технологийн дагуу чанар, аюулгүй байдлыг хангаж баригдаж байгаа эсэхэд хяналт тавина.

4.2 Зохиогч нь барилгын ажилд хяналт гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, санхүүжилтийн зардлын тооцоог Төвтэй тохиролцон баталгаажуулж гэрээнд хавсаргана.

4.3 Зохиогч нь хяналтын инженерүүдийг барилгын талбайд ажиллах нөхцөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүйн ажиллагааны хувцас, хэрэгсэл, хэмжих багаж, тээврийн хэрэгслэлээр хангана.

4.4 Зохиогч нь барилгын ажлын явцад барилгын норм, дүрэм, стандарт, технологийн горим, техникийн нөхцөл зөрчсөн, батлагдсан зураг төсөл өөрчилсөн зөрчил дутагдал илэрсэн тухай бүрт засаж залруулах зөвлөмж, шаардлага тавьж Төв болон холбогдох эрх бүхий байгууллага, хүмүүст мэдэгдэж уг зөрчлийг хэрхэн, хэдий хугацаанд арилгах тухай саналыг албан бичиг, бусад эрх зүйн актаар гаргана.

4.5 Барилгын ажлын далдлагдах хийц бүтээцийн хэсгүүдэд тухай бүр хяналт тавьж ил, далд ажлын актын хамт “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм /БНБД 11-04-16/-ийн хавсралт 1 хүснэгтийн 10-43-д заасны дагуу шалгах хуудсанд тэмдэглэл хөтөлж баталгаажуулна.

4.6. Төвөөс гаргасан хүсэлтийн дагуу энэхүү гэрээнд тусгагдаагүй дараах нэмэлт ажилд зохиогчийн хяналт гүйцэтгэж болно.

а. Төвөөс ирүүлсэн тухайн барилгын батлагдсан зураг төсөлд заагдсантай дүйцэхүйц эсвэл дэвшилтэт Монгол Улсад дагаж мөрдөж буй стандарт шаардлага хангасан материал хэрэглэх санал, мөн зураг төсөлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагын тухай төвийн албан бичиг хавсралт материалуудыг судалж гүйцэтгэгч, бусад холбогдох байгууллагатай зөвшилцэж дүгнэлт гаргаж, зураг төслийг гүйцэтгэнэ.

б. Зохиогчийн хяналт хэрэгжүүлэх явцад зайлшгүй шаардлагатай бол холбогдох мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийг оролцуулах

в. Барилгын гадна, дотор засал, орчны тохижилтод хяналт тавьж зөвлөгөө өгөх

г. Барилга байгууламжийн зураг төсөл зохиох норм ба дүрэм, стандарт, техникийн нөхцөлд өөрчлөлт орсон шалтгаанаас батлагдсан зураг төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах зургийн ажлыг хийж гүйцэтгэх

д. Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн /газар хөдлөл, гал, усны үер, гамшиг/ улмаас барилгын хийц бүтээцэд үүссэн гэмтэлийн шалтгааныг тогтоож түүнийг засварлах талаар санал дүгнэлт гаргах, зөвлөгөө өгөх

4.7 Батлагдсан ажлын зураг төсөлд Төвийн хүсэлтээр тайлбар хийх, зөвлөгөө өгөх, Төв болон барилгын ажлын гүйцэтгэгч нарын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэхэд мэргэжлийн дүгнэлт гаргаж ажиллана.

4.8 Зохиогч барилгын ажлын гүйцэтгэгчийн барилга угсралтын ажлын графикийн биелэлтэд хяналт тавих үүрэггүй.

4.9 Зохиогч гэрээний болон бусад хугацаанд барилгын талбайд нэвтрэх бүрэн эрхтэй.

4.10 Зохиогч хяналт тавих явцад барилгын аль ч хэсгийн хийц бүтээц, эдлэхүүнд хэмжилт, шалгалт, туршилт хийх талаар барилгын ажил гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

4.11 Хэрэв барилгын ажлыг батлагдсан зураг төслийн баримт бичгийн дагуу гүйцэтгэгүй, барилгын норм, дүрэм, стандартыг зөрчиж чанар аюулгүй байдлын шаардлага хангаагүй бол барилгын ажлыг түр зогсоох хүсэлтийг холбогдох дүгнэлтийн хамт мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлнэ.

4.12 Зохиогч Төвийн албан бичгээр өгсөн зөвшөөрлөөр барилгын ажлын тодорхой асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагад хандаж болно.

4.13 Зохиогч барилгын ажилд хэрэглэгдэж байгаа хийц бүтээц, эдлэхүүн, материалуудын лабораторийн сорил шинжилгээний дүгнэлт, техникийн баримт бичиг, гарал үүслийн гэрчилгээ зэрэгтэй танилцах, шалгах эрхтэй

4.14 Зохиогч барилгын ажилд ноцтой зөрчил, чанарын доголдол гаргаж хохирол учруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэх талаар холбогдох байгууллагад хандах эрхтэй

4.15 Зохиогч өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар барилгын ажил зогссон бол Төвөөс гэрээний хугацааг сунгахыг шаардах эрхтэй.

4.16 Зохиогч гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй, гүйцэтгэсэн ажилдаа алдаа, чанарын доголдол гаргасан бол үүссэн хохирлыг барагдуулах үүрэгтэй.

4.17 Зохиогч барилгын явцад илэрсэн алдаа, дутагдал, доголдлыг арилгах талаар зураг төслийн болон бусад техникийн баримт бичигт тусгаагүй бол холбогдох хариуцлага хүлээнэ.

4.18 Зохиогчийн боловсруулсан зураг төсөлд оруулсан нэмэлт өөрчлөлт нь шаардлага хангаагүй бол Төвийн шаардлагын дагуу уг ажлыг зохиогч өөрийн зардлаар нөхөн гүйцэтгэх ба гарсан хохирлыг хариуцна.

4.19 Барилгын ажлын явцад зохиогчийн буруутай үйлдлээс аваар осол, эвдрэл гэмтэл гарвал, боловсруулж батлуулсан зураг төслөөр баригдсан барилга нь хүний эрүүл мэнд, орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхээр байгаа бол Зохиогч хариуцлага хүлээж хохирлыг барагдуулна.

Тав. Гэрээний хүчинтэй хугацаа, гэрээнд өөрчлөлт оруулах, цуцлах үндэслэл

5.1 Энэхүү гэрээ нь талуудын гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчинтэй. Гэрээний хүчинтэй хугацаа нь Төвтэй байгуулсан барилгын ажлын эхлэх, дуусах, ашиглалтад хүлээлгэн өгөх хугацаа байна. Гэхдээ “Барилгын тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.7 дахь заалтын хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

5.2 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвхөн гэрээ байгуулсан хоёр талын зөвшилцлөөр хийгдэх бөгөөд талуудын эрх бүхий хүмүүсийн гарын үсгээр баталгаажуулснаар үндсэн гэрээний салшгүй хэсэг болно

5.3 Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл нь талуудын төлөөлөгчдийн уулзалт, хэлэлцээрийн үед тохиролцон гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан холбогдох баримт бичиг байна.

5.4 Энэхүү гэрээг Төв болон зохиогчийн харилцан тохирсон баримт бичгээр цуцалж болно.

5.5 Төв дараах нөхцөлд өөрийн санаачлагаар нэг талаас гэрээг цуцлах эрхтэй:

5.5.1 Зохиогч гэрээ батлагдсан өдрөөс хяналтыг хэрэгжүүлэлгүй барилгын тодорхой үе шатны ажлыг гүйцэтгүүлсэн эсвэл зохиогчийн хяналт тавих ажлын явц байдал гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлэх боломжгүй болох нь тодорхой болвол,

5.5.2 Зохиогчийн хяналт тавих ажлын явцад ажлын зураг төсөл болон бусад техникийн баримт бичгийн шаардлага зөрчсөн зөвлөмж өгсөн, Төвтэй зөвшилцөлгүйгээр гүйцэтгэгчтэй тохиролцон шийдвэр гаргасан,

5.5.3 Зохиогч гэрээний нөхцөлийг биелүүлэхгүй байх эсвэл хяналт тавьсан барилгын ажилд зохиогчийн гарсан зөрчил засаж арилгахад төвөгтэй нөхцөл байдал үүсгэвэл,

5.5.4 Зохиогч үндэслэлгүйгээр энэхүү гэрээгээр тохиролцсон үнийн дүнг нэмэгдүүлвэл,

5.5.5 Гэрээгээр зохиогчийн хяналт тавьж буй барилгын ажлыг дур мэдэн зогсоовол,

5.5.6 Зохиогчийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл /лиценз/ цуцлагдвал,

5.6 Зохиогч дараах тохиолдолд өөрийн санаачлагаар нэг талаас гэрээ цуцлах эрхийг эдэлнэ:

5.6.1 Төв зохиогчийн хийсэн ажлын хөлсийг төлөхөөс татгалзвал хохирлоо барагдуулж гэрээ цуцлах

5.6.2 Зохиогчийн зүгээс Төвийн гаргаж өгсөн мэдээлэл, баримт материал нь ажлын үр дүнд сөрөг нөлөө үзүүлэх эсвэл шаардлага хангахгүй байгаа талаар албан бичгээр мэдэгдсээр байтал арга хэмжээ аваагүй, үүнээс үүдэн гэрээт ажлыг зохиогч хугацаанд нь дуусгах боломжгүй нөхцөл байдал үүсвэл,

5.6.3 Зохиогчтой зөвшилцэлгүйгээр Төв нь гүйцэтгэгчтэй тохиролцон зураг төсөл өөрчлөн барилгын ажлыг гүйцэтгэсэн бол.

5.7 Талуудын аль нэг тал өөрийн санаачлагаар гэрээг цуцлах бол хуанлийн 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ. Уг мэдэгдлийн хариуг мэдэгдэл өгсөн өдрөөс хуанлийн 30 хоногийн дотор ирүүлээгүй бол санаачлагч тал гэрээг цуцалж ажлаа зогсооно.

5.8 Давагдашгүй хүчин зүйлс тохиолдсоноос үссэн хохирол тодорхой баримтаар батлагдаж гэрээнд оролцогч талууд ажлаа зогсооход хүрвэл энэхүү нөхцөл байдлаас бий болсон бодит хохирлыг арилгах хариуцлагаас чөлөөлөгднө. Гэхдээ үүнээс үссэн хохирлыг хэрхэн шийдвэрлэх талаар талууд харилцан тохиролцож даатгалын байгууллагатай хамтран ажиллана.

Зургаа. Ажлын үр дүнг ашиглах, зохиогчийн эрхийг хамгаалах

6.1 Гэрээний дагуу зураг төсөлд оруулсан нэмэлт өөрчлөлт, холбогдох баримт бичиг нь захиалагчийн мэдэлд байж тэдгээрийг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд захиран зарцуулах эрхтэй.

6.2 Төв нь гэрээний дагуу зохиогчоос боловсруулсан бүх баримт бичиг түүний доторх мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүй. Төрийн байгууллагуудын шаардлагын дагуу дээрх баримт бичиг, мэдээллийг холбогдох газруудад өгөх нь тус заалтад хамаарахгүй болно.

6.3 Зохиогч нь зураг төслийн баримт бичгийн зохиогчийн эрхийг эдэлж байгаагийн хувьд уг баримт бичгийг боловсруулсны үнэ хөлс төлөгдсөнийг үл харгалзан зураг төсөл, техникийн нөхцөл бусад баримт бичгийг ашиглах эрхтэй. Харин энэхүү гэрээний дагуу боловсруулсан нэмэлт зураг төсөл, баримт бичгийг захиалагчийн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх эрхгүй.

6.4 Зохиогч Төвөөс ирүүлсэн мэдээллийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс өөр зорилгоор ашиглахгүй.

6.5 Захиалагч шинэ бүтээлийн эзэмшигчтэй лицензийн гэрээ байгуулж шинэ бүтээл, ноу-хау, дэвшилтэд загвар зэрэг оюуны өмчийг ашиглах талаар тохиролцсон нөхцөлд зохиогчийн зураг төслийн баримт бичигт түүнийг ашиглуулна.

6.6 Зохиогч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад гаргасан шинэ бүтээл нь түүний оюуны өмч бөгөөд түүнийгээ зохих журмаар баталгаажуулна.

6.7 Зохиогч гэрээгээр гүйцэтгэсэн ажлаа өөрийн байгууллагаа сурталчлах зорилгоор тухайн барилга байгууламжийн зураг төслийг ашиглаж болно. Эдгээр материал нь захиалагчийн нууцтай холбоогүй байх ёстой.

Долоо. Гэрээгээр гүйцэтгэх ажлын үр дүнг баримтжуулах, хүлээлгэн өгөх

7.1 Барилгын ажилд зохиогчийн хяналт тавьсан ажлын гүйцэтгэлийн үр дүнг баримтжуулах баримт бичигт:

7.1.1 Барилгын үе шатны болон ил, далд ажлын акт, "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм /БНБД 11-04-16/-ийн хавсралт 1-ийн хүснэгт 10-43-ийн дагуу баталгаажуулсан шалгах хуудас, фото зураг,

талбайн ажлын журналд тэмдэглэсэн зөвлөмж, шаардлага тэдгээрийн биелэлт,

7.1.2 Барилга байгууламжийн ашиглалтад хүлээн авахтай холбоотой бусад баримт бичиг,

7.1.3 Батлагдсан зураг төсөлд тодруулга хийх,

7.1.4 Зураг төсөлд өөрчлөлт оруулсан тухай зөвлөмж, гүйцэтгэлийн зураг төсөл.

7.2 Зохиогч гэрээнд заасны дагуу барилгын ажилд хяналт тавьсан тухай баримт бичиг, ажлын төлөвлөгөө, санхүүжилтийн зардлын тооцооны тайланг цаг тухай бүрд бүрдүүлэн Төвд нэг хувийг хүлээлгэн өгнө.

7.3 Төв 6.1-д заасан техникийн баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор гүйцэтгэсэн ажлын чанарын талаар гомдол гаргах эрхтэй. Хэрэв Захиалагч гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хариу өгөөгүй бол дээрх техникийн баримт бичгийг хүлээн авсанд тооцно.

7.4 Зохиогч Төвөөс албан бичгээр гаргасан гомдол, саналыг хүлээн авч засаж залруулах, гүйцэтгэх хугацааг тодорхойлон хариу албан бичгээр мэдэгдэнэ.

Найм. Ажлын үнэлгээ, төлбөр тооцоо

8.1 Төв нь Захиалагчаас шилжүүлсэн зохиогчийн хяналтын зардлыг өөрийн дансанд хүлээн авсны дараа барилгын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгэсэн ажлын төлөвлөгөө, санхүүжилтийн тайлан, гэрээний хуулбар, төлбөрийн нэхэмжлэх, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 60 хүртэлх хувийг үе шаттайгаар Зохиогчид олгож болно. Үлдэгдэл 40 хүртэлх хувийн зардлыг барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулсан комиссын дүгнэлт, дээрх холбогдох баримт материалыг үндэслэн олгоно.

8.2 Талууд харилцан тохиолцсоны дагуу 3.3-д заагдсан нэмэлт ажлуудыг гүйцэтгэсэн бол ажлын хөлсийг нэмэлт гэрээнд заасны дагуу төлнө.

8.3 Зохиогч 8.1-д заагдсан холбогдох баримт материалыг бүрдүүлэн Төвд албан бичгээр хүргүүлэх ба төлбөрийг Төв хүлээн авсан өдрөөс хойш ажлын 21 хоногт багтаан шилжүүлнэ. Захиалагчаас Төвийн дансанд шилжүүлээгүй зохиогчийн хяналтын зардал уг заалтад хамаарахгүй болно.

8.4 Төв нь ажлын хөлсийг 8.3-д заасан хугацаанд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс бусад тохиолдолд шилжүүлээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн алдангийг зохиогчид төлнө. Нийт алданги нэхэмжилсэн үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй.

8.5 Шүүхийн байгууллага маргааныг авч шийдвэрлэх хүртэл хугацаанд зохиогчийн хяналтыг гэрээний дагуу үргэлжлүүлэх бөгөөд шүүхийн шийдвэрийн дагуу гүйцэтгэсэн ажлын хөлсийг тооцно.

8.6 Төв нь зохиогчийн хяналтын гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг үндэслэлгүйгээр хүлээн авахаас татгалзсан нь тогтоогдвол 8.5-д заасан хугацаанаас хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн алданги тооцно. Нийт алданги нэхэмжилсэн үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй.

8.7 Зохиогч гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээт ажлын үнийн дүнгийн 0.1 хувтай тэнцэх алдангийг Төвөөс зохиогчид шилжүүлэх зардлаас суутгах ба нийт алдангийн зардлаас суутгах хэмжээ гэрээт ажлын үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй.

8.8 Зохиогчоос үл хамаарах шалтгаанаар барилгын ажил түр хугацаагаар зогсож гэрээний хугацаа сунгагдсан тохиолдолд алданги тооцохгүй.

8.9 Талуудын санаачлагаар ажил гүйцэтгэх гэрээг цуцалсан тохиолдолд шаардлагатай бол зохиогчид гэрээ цуцлах хүртэл гүйцэтгэсэн ажлын зардлыг тооцож олгож болно.

Ес. Бусад заалт

9.1 Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.2 Нэмэлт гэрээнд оруулсан өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэж хоёр талын эрх бүхий хүмүүсийн гарын үсэг, байгууллагын тамга тэмдэгтээр баталгаажуулсан байна.

9.3 Гэрээний хавсралтууд:

1-р хавсралт. Барилгын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгэх ажлын төлөвлөгөө,

2-р хавсралт. Барилгын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгэх санхүүжилтийн зардлын тооцоо,

3-р хавсралт. Зохиогчийн хяналт гүйцэтгэгч заавал оролцож бурдүүлэх баримт бичиг, ил, далд ажлын актууд,

Эдгээр нь уг гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээтэйгээ адил хүчинтэй.

9.4 Талуудаас үл хамаарах, давагдашгүй хүчин зүйлс (байгалийн гамшиг, гал усны аюул, эдийн засгийн хямрал зэрэг)-ийн улмаас гарсан хохирлыг талууд хариуцахгүй бөгөөд уг нөхцөл байдлаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болвол энэхүү гэрээг дуусгавар болгоно.

9.5 Уг гэрээг байгуулахын өмнө талуудын хооронд явуулсан хэлцэл, захидал, бусад баримт бичгийг гэрээнд хавсаргах ба гарын үсэг зурсан өдрөөс хүчингүйд тооцно

Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгчийг төлөөлж:

Барилгын хөгжлийн төвийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Т.Нямдаваа

Барилгын хөгжлийн төвийн Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтсийн дарга

Г.Гантуул

1/29/2014

Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламж захиалагчийн хяналтын хэлтсийн дарга

Э.Мөнхсүх

Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Их тойруу-1, Барилгын хөгжлийн төв.

Утас: 11-327442.

Факс: 976-11-323744

Зураг төсөл зохиогчийг төлөөлж:

“Барилга байгууламж” ХХК-ийн менежер

М.Болдбаяр

“Барилга байгууламж” ХХК-ийн нягтлан бодогч

М.Мэнджарагал

Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг. 3-р хороо Жуулчны гудамж, Капитал төв 603тоот

Утас: 99017077, 99108566

Факс:

Харилцах банк, дансны дугаар:
Хаан банк – 5315005406

Хавсралт. №1.

БАТЛАВ. Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн дарга

2019/02 Э.Мөнхсүх

Барилга угсралтын ажлын гэрээний дугаар: ТӨБЗГ-2019/XII.2.1.52

Барилга байгууламжийн нэр: Говь-Алтай аймаг Бугат сум, 150 суудалтай соёлын төвийн барилга

Зохиогчийн хяналт хийх үе шат, зардлын тооцоо


№	Барилга угсралтын үе шат	Эхлэх, дуусах хугацаа/сар, өдөр/	Хүний тоо	Хяналтын тоо	Зардал /төгрөг/
I	Барилгын суурийн ажил/1 удаа/				
1.	Газар шорооны ажил, суурийн нүх ухсаны дараа Суурийн ул, цутгалт, арматурчлал Давхруудын шал, багана, дамнуу, хучилтын арматурчлал, цутгалтын ажлын үе шат	2019.10.01- 2020.05.30	2	1	6 000 000
II	Гадна, дотор ханын угсралт, өрлөгө, гадна заслал, тохижилт үе шат /1 удаа/				
2.	Барилгын гадна ханын угсралт, өрлөгийн ажил Гадна шат пандусны цутгалтын ажил Дотор ханын угсралт, өрлөгийн ажил Заслын ажил Гадна заслалын ажлын үе шат Гадна тохижилтын ажил Дээврийн ажил	2020.06.01-08.01	1	1	4 500 000

V	Дотор халаалт, агаар сэлгэлт, цэвэр бохир ус, холбоо дохиолол, цахилгааны угсралтын үе шатанд /1 удаа/					
7.	Дотор халаалт, агаар сэлгэлт, цэвэр бохир ус, холбоо дохиолол, цахилгааны ажил	2020.07.01-2020.08.01	1	1		1 000
VI	Гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил /1 удаа/					
8.	Ус хангамж ариутгах татуургын угсралт Гадна дулааны угсралт Гадна цахилгааны ажлын угсралт Гадна холбооны ажлын угсралт	2020.07.01-08.15	1	1		1 000
VII	Нийт	Улсын комисс ажиллах	2020.08.15	4	1	813
						12,813,700

Хянасан:

Хянасан:

ББЗХХ-ийн ахлах инженер.....  Б.Амарзаяа

ББЗХХ-ийн хяналтын инженер.....  Ж.Лхамаа

Боловсруулсан:

Барилгын зураг төслийн “Барилга байгууламж” ХХК-ийн инженер

 M.Болдбаяр

БАТЛАВ. Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн дарга. Э.Менхсүх

Барилга угсралтын ажлын гэрээний дугаар: ТӨБЗГ-2019/XII.2.1.52

Барилга байгууламжийн нэр: Говь-Алтай аймаг, Бугат сум, 150 суудалтай соёлын төвийн барилга

Барилга угсралтын үе шатны ажлын явцад зохиогчийн хяналт хийх график.

№	Зураг төслийн аль хэсэг болох	Зохиогчийн хяналт хийх хүний нэр, мэргэжил Утас:	2019 он	2020 он							
			10-11	3	4	5	6	7	8	9	10
1	Барилга-архитектур	М.Цэнд-Аюуш 99790009					6				
2	Барилга бүтээц	Ө.Цогтэрэл 88998006									
3	Халаалт салхивч	Ч.Нарандэлгэр 99017077									
4	Цэвэр бохир ус	С.Бадамханд 99078841									
5	Цахилгаан	Г.Нарантуяа 99787923									
6	Холбоо дохиолол	Д.Солонго 99332282									
7	Гадна дулаан	Ч.Нарандэлгэр					6				
8	Гадна цэвэр бохир ус	С.Бадамханд									
9	Гадна цахилгаан	Г.Нарантуяа									
10	Гадна холбоо	Д.Солонго					6				
11	Улсын комисс /99102201,88884547/							6			


Хянасан:

ББЗХХ-ийн ахлах инженер..... Б.Амарзаяа

ББЗХХ-ийн хяналтын инженер.... Ж.Лхамаа

Боловсруулсан: Барилгын зураг төслийн Барилга байгууламж" ХХК-ний

Захидал..... Ч.Нарандэлгэр



БАТЛАВ:

БОЛОВСРОЛ СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

XII.2.1.52. СОЕЛЫН ТӨВИЙН БАРИЛГА, 150 СУУДАЛ ГОВЬ-АЛТАИ, БУГАТ СУМ/
УГСРАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

"АКСУ-АЛТАЙ" ХХК-ИН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

С.ЧЭРЭНДОЛГОР
АКСУ-АЛТАЙ
ХХК

Ц.ЧЭРЭНДОЛГОР

1115205432 2729822

2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар: ТӨБЗГ-2019/XII.2.1.52

Нэг талаас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (цаашид "захиалагч" гэх), нэгөө талаас "Аксу-Алтай" ХХК (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиорлцож 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй Говь-Алтай аймгийн Бугат сумын Соёлын төвийн барилга /цаашид "барилга" гэх/ барихтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Гүйцэтгэгч нь Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх дээрх соёлын төвийн барилга угсралтын иж бүрэн ажлыг (цаашид "ажил" гэх) 1,551,931,934.0 /нэг тэрбум таван зуун тавин нэгэн сая есөн зуун гучин нэгэн мянга есөн зуун гучин дөрөв/ төгрөгөөр гүйцэтгэнэ. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний дүн: 1,551,931,934.0 төгрөг

Үүнээс:

- | | |
|--|------------------------|
| • Барилга угсралтын ажлын дүн | 1,281,369,972.0 төгрөг |
| • Техник хяналтын зардал | 25,627,399.0 төгрөг |
| • Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал | 12,813,700.0 төгрөг |
| • Магадлашгүй ажлын зардал | 25,627,399.0 төгрөг |
| • Инженер хайгуул, зураг төслийн зардал | 23,760,000.0 төгрөг |
| • Тоног төхөөрөмжийн зардал | 37,300,000.0 төгрөг |
| • Гүний худаг гаргах зардал | 15,000,000.0 төгрөг |
| Гүйцэтгэлийн баталгаа | 5.0 % |

4. Гүйцэтгэгч нь гэрээний 2 дахь хэсэгт заасан барилга угсралтын ажлыг 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд батлагдсан ажлын зураг төслийн дагуу бүрэн хийж гүйцэтгэнэ.

5. Дор дурьдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх)

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Гэрээний тусгай болон нэмэлт нөхцөл;

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗҮҮГАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2019 оны 05 дугаар
сарын 13-и
өдөр

Дугаар 559/2019

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс: 976-11-320338

Объектын байршил, нэр:	Говь-Алтай аймгийн Бугат сумын 5-р багийн нутаг дэвсгэрт баригдах "150 хүний суудалтай соёлын төвийн барилга"-ын ажлын зураг төсөл, төсөв ШИФР: ББ-12/2019		
Хүчин чадал:	Соёлын төвийн барилга нь тэнхлэгээрээ 36.0 м x 24.0 м хэмжээтэй, ± 0.00 түвшнээс доош зоорийн давхаргүй, ± 0.00 түвшнээс дээш 2 давхар, 150 хүний суудалтай. Тогооны барилга нь тэнхлэгээрээ 7.0 м x 6.0 м хэмжээтэй, ± 0.00 түвшнээс доош зоорийн давхаргүй, ± 0.00 түвшнээс дээш 1 давхар,		
Захиалагч:	Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам		
Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар		
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр,	"Барилга байгууламж" ХХК		
Регистрийн дугаар:	РД: 2023024		
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2022.03.09		
Ажилбарын төрөл:	1.2.2, 1.2.4, 1.2.5, 1.2.6, 1.3.1, 1.3.2, 1.3.3, 1.3.5, 1.5.1 заалтын дагуу		
Зураг төсөл боловсруулах үндэслэл:	Говь-Алтай аймгийн Бугат сумын Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/07 тоот захирамж, Газар эзэмших эрхийн 000005226 дугаартай гэрчилгээ		
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	Говь-Алтай аймгийн Ерөнхий архитектор бөгөөд Барилга, Хот байгуулалтын хэлтгийн даргын баталсан 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 30/2019 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар		
Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газар, "Барилга байгууламж" ХХК нарын хооронд байгуулсан 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн ГААОНӨГ/201901006 дугаартай зураг төсөл боловсруулах гэрээ		
Зураг төсөл боловсруулах үндэслэл:	Говь-Алтай аймгийн Бугат сумын Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 02 тоот албан бичиг		
Техникийн нөхцөлүүд:	Олгосон байгууллага	Дугаар, огноо	Хүчинтэй байх хугацаа
Дулаан хангамж:	Говь-Алтай аймгийн Бугат сумын Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 02 тоот албан бичиг		
Үс хангамж, ариутгах татуурга:	"АУЭХС" ТӨХК № 233		
Цахилгаан хангамж:	2019.04.10-ны ТН-A10/2019		
Холбоо, дохиолол:	"МХС" ХХК	2019.02.15-ны	1 жил
Зөвшөөрөлцөн байгууллагууд :	Говь-Алтай салбар	ТН-A10/2019	1 жил

Говь-Алтай аймгийн Ерөнхий архитектор	Б.Бямбадорж	
Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын дэргэ, Дэд хурандаа	З.Баттулга	
“АУЭХС” ТӨХК-ийн ерөнхий инженер	Б.Бээжин	
“МХС” ХХК-ийн Говь-Алтай аймгийн газрын ерөнхий инженер	Д.Цэвэлмаа	
Зураг төслийн бүрэлдэхүүн:		
Зургийн бүрдэл:	Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Шалгасан экспертийн нэр:
Ерөнхий төлөвлөгөө, ендөржилт:	“Барилга байгууламж” ХХК	Д.Буяントгох
Барилга архитектур:	“Барилга байгууламж” ХХК	Д.Буяントгох
Барилга бүтээц:	“Барилга байгууламж” ХХК	Б.Оюун
Дулаан хангамж:	“Барилга байгууламж” ХХК	Ц.Нарантуяа
Гадна, дотор ус хангамж, ариутгах татуурга:	“Барилга байгууламж” ХХК	Д.Дагвасүрэн
Цахилгаан хангамж:	“Барилга байгууламж” ХХК	Д.Амгалан
Гадна, дотор холбоо, дохиолол:	“Барилга байгууламж” ХХК	Ж.Өлзийбаяр
Төсөв:	“Барилга байгууламж” ХХК	Ч.Мөнхтуяа
Инженер геологи:	“БАРНАБ” ХХК /Архив № 49/19/	Дүгнэлт баталгаажсан О.Балдорж
Ерөнхий дүгнэлт: /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол/	Барилга байгууламжийн техникийн ерөнхий өгөгдөл: Говь-Алтай аймгийн Бугат сумын 5-р багийн нутаг дэвсгэрт баригдах “150 хүний суудалтай соёлын төвийн барилга”-ыг Говь-Алтай аймгийн Бугат сумын Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/07 тоот захирамжаар олгогдсон 1000 м ² талбайд байршуулахаар төлөвлөж, Говь-Алтай аймгийн Ерөнхий архитектор бөгөөд Барилга, Хот байгуулалтын хэлтсийн даргын баталсан 2019 оны 04 дугаар сарын 05-ны өдрийн 30/2019 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэн зураг төслийг боловсруулжээ.	
Барилга байгууламжийн техникийн ерөнхий өгөгдлийн болон техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт:	Байгаль цаг уурын өгөгдэл: Гадна агаарын температур -39.0 °C Цасны ачаалал 50 кг/м ² Салхины ачаалал 34 кг/м ² Галд тэсвэрлэлтийн зэрэг II Барилгын ангиал 2 Барилгын буурь хөрсний үзүүлэлт: Суурь суух буурь хөрс нь орчин үеийн дээд дунд дөрөвдөгчийн настай, делювийн гаралтай, бор саарал өнгөтэй, хатуу хам байдалтай, хайрга агуулсан шавранцар ул хөрс бөгөөд хөрсний ус илрээгүй, инженер геологийн энгийн нөхцөлтэй, газар хөдлөлийн 9 баллын бүсэд хамаарна. Суурь суух буурь хөрсний механик шинж чанарын үзүүлэлт нь: Барьцалдах хүч: С ^н =39 кПа Дотоод үрэлтийн өнцөг: Ф ^н =25° Хэв гажилтын модуль: Е=28 МПа Тооцооны эсэргүүцэл: R _o =300 кПа Хөрсний цахилгаан эсэргүүцэл: 18-44 Ом.м Улирлын хөлдөлтийн гүн: 2.10 м Барилга байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:	

Соёлын төвийн барилгыг тэнхлэгээрээз 36.0 м x 24.0 м
хэмжээтэй, ± 0.00 түвшнээс доош зоорийн давхаргүй,
± 0.00 түвшнээс дээш 2 давхар байхаар төлөвлөж,

1-р давхарт: Гонх, вестибюль, өлгүүрийн өрөө, ариун
цэврийн өрөө, кассын өрөө, цахилгааны узель, хөгжим
бэлтгэлийн заал, үзвэрийн заал, тайз, хувцас солих өрөө,
тайзны арын өрөө, агуулахыг,

2-р давхарт: Эрхлэгчийн өрөө, санхүүгийн өрөө, номын
фонд, уншлагын танхим, техникийн өрөө, үзвэрийн
хэсэг, видео зураг авах хэсэг, музей, захиргаа аж ахуйн
өрөө, бүжгийн бэлтгэлийн заал, хувцас солих өрөө
байхаар тус тус төлөвлөсөн байна.

"Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн
гарын авлага" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй
иргэдийн амьдрах орон зай, орчны зураг тесел
төлөвлөлт" /БД 31-112-11/-ийн дагуу хөгжлийн
бэрхшээлтэй иргэдэд зориулж налуу зам төлөвлөсөн
байна.

Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл:

Суурь: Цутгамал төмөр бетон баганан суурьтай,
Даацын үндсэн бүтээц: Цутгамал төмөр бетон арагт
бүтээцтэй,"

Гадна хана: 360 мм-ийн хөнгөн блокон дүүргэгч ханатай,
150 мм-ийн зузаантай хөөсөн полистрол хавтан
дулаалгатай,

Хучилт: Цутгамал төмөр бетон хучилттай,

Дээвэр: Шувуу нуруу бүхий 2 налуутай болон хавтгай
дээвэртэй байхаар тус тус төлөвлөжээ.

Халаалт, агаар сэлгэлт:

Барилгын халаалтыг доогур түгээлттэй хоёр хоолойт
мухардмал эргэлттэй систем, агаар сэлгэлтийг ердийн
болон механик ажиллагаатай системтэй байхаар тус тус
төлөвлөсөн байна.

Дулаан зөөгчийн температур 90°/70°C.

Дулааны нийт ачаалал: $Q_{бұғд}=110000$ ккал/цаг,

Цэвэр, бохир ус:

Барилга доторх ус хангамжийг ахуйн болон галын ус
хангамжийн системтэй байхаар төлөвлөж, бохир усыг
өөрийн урсгалаар нь нэгтгэн шинээр төлөвлөж буй бохир
усны цооногт холбож зайлцуулахаар төлөвлөсөн байна.

Цэвэр, бохир усны тооцоо: $q_{бұғд}=2.66 \text{ м}^3/\text{хон}$,
 $q_{ху}=1.34 \text{ м}^3/\text{хон}$, $q_{хал}=1.32 \text{ м}^3/\text{хон}$, $q_{бох.ус}=2.66 \text{ м}^3/\text{хон}$,

Дотор гэрэлтүүлэг, хүчин төхөөрөмж:

Тус барилга нь цахилгаан хангамжийн найдвартай
ажиллагааны II зэрэгт хамрагдах ба тэжээлийг гүн
газардуулсан нейтральтай хос кабель шугамаар
тэжээхээр төлөвлөж газардуулга, аянга хамгаалалтыг
төлөвлөсөн байна.

Газардуулгын эсэргүүцэл 4 Ом-с хэтрэхгүй байна.

Цахилгааны оролт: $P_t=62.23 \text{ кВт}$, $I_t=105.11 \text{ A}$,

Дотор холбоо, дохиолол:

Барилгад телефон холбоо, интернет сүлжээ, кабелийн
телевиз, галын дохиолол, хяналтын өмч, зарлан
мэдээлэх системийг тус тус хийхээр төлөвлөсөн байна.

Гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлт:

Гадна дулаан хангамж:

	<p>Барилгын дулаан хангамжийг шинээр төлөвлөж буй тогооны барилгаас хангахаар төлөвлөж, НР-25Ж маркийн $\Phi 1200$ мм, Н=2000 мм хэмжээтэй, Q=170000 ккал/цаг дулаан гаргах чадалтай 2 ширхэг усан халаалтын тогоо суурилуулахаар төлөвлөсөн байна.</p> <p>Ус хангамж, ариутгах татуурга:</p> <p>Барилгын цэвэр усыг шинээр гүний худаг гарган холбооор төлөвлөж, барилгаас гарах бохир усыг $\Phi 110$ мм, $\Phi 160$ мм-ийн голчтой хуванцар хоолойгоор шинээр төлөвлөж буй 30 м³-ийн багтаамжтай бохир усны цооногт холбож зайлуулахаар төлөвлөсөн байна.</p> <p>Гадна цахилгаан хангамж:</p> <p>Цахилгааны тэжээлийг техникийн нөхцөлийн дагуу одоо байгаа 160 кВа 15/0.4 кВ-ын агаарын дэд станцыг 250 кВа болгон өргөтгэж, төгсгэлийн шонд 0.4 кВ-ын хуваарилах самбар тоноглон уг хуваарилах самбараас төлөвлөж буй барилга хүртэл АВББШв маягийн 3x50+1x25 мм²-ийн хөндлөн огтлолтой хос кабель шугам татаж тэжээхээр төлөвлөсөн байна.</p> <p>Гадна холбоо, дохиолол:</p> <p>Тонхил сумын холбооны салбарын төхөөрөмж байрлах өрөөнд 4 шөрмөсийн шилэн кабелийн төгсгэлийн төхөөрөмжид FDF суурилуулан цэнэглэж, 4 шөрмөсийн шилэн кабелийг одоо байгаа болон шинээр суурилуулах баганаар дамжуулан барилгад оруулан төгсгэлийн төхөөрөмжид холбооор төлөвлөсөн байна.</p>
Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаархи тодорхой санал, дүгнэлт:	<p>Зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдлийг холбогдох орон тооны бус экспертууд шалгаад: Экспертуудийн өгсөн үүрэг даалгаврын дагуу зураг төсөлд засвар өөрчлөлтүүдийг хийсэн байна.</p>
Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үөйн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан гаргасан хөрөнгө оруулалтын үр ашигийн талаархи дүгнэлт.	<p>"Соёлын төвийн барилга" баригдсанаар ажилчдын ажиллах орчин сайжирч, ажлын байр нэмэгдэх, урлаг соёлын арга хэмжээг стандартын шаардлага хангасан орчинд зохион байгуулах, иргэд чөлөөт цагаа зөв зохистой өнгөрөөх таатай нөхцөл бүрдэх юм.</p>

Говь-Алтай аймаг, Бугат сум 5-р баг "150 хүний суудалтай соёлын төвийн барилга"-ын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчоо

№	Тодорхойлолт	Барилга угсралтын ажлын		
		Төсөвт өртөг /төг/	Хүчин чадал	Нэгж өртөг /төг/
1	a/. Барилга угсралтын ажил /соёлын төвийн барилга/:			
ББ	Барилга: 36.0 м x 24.0 м хэмжээтэй	1,387,354,736.0	1,314.0	1,055,825.5
ХАС	Давхрын тоо: Зоорьгүй, 2 давхар Талбайн хэмжээ: 1,314.0 м ²	92,894,513.0	1,314.0	70,696.0

Төвь-Алтай аймгийн Бугат сумын 5-р багийн нутаг дэвсгэрт баригдах
“150 хүний суудалтай соёлын төвийн барилга”-ын ажлын зураг төсөл, төсөв

ЦБУ	Суурь: Цутгамал төмөр бетон баганан	34,031,745.0	1,314.0	25,899.3
ДГ-ХТ	Үндсэн хийц: Төмөр бетон каркас Гадна хана: 360 мм-ийн хөнгөн блок, 150 мм-ийн хөөсөнцөр хавтан дулаалга,	50,952,155.0	1,314.0	38,776.4
ХД	Хучилт: Цутгамал төмөр бетон Дээвэр: Дулаалгатай хавтгай	23,509,172.0	1,314.0	17,891.3
	Хэсгийн дүн:	1,588,742,321.0	1,314.0	1,209,088.5
2	б/. Барилга угсралтын ажил /халаалтын зуухны барилга/: Барилга: 7.0 м x 6.0 м хэмжээтэй Давхрын тоо: Зоорьгүй, 1 давхар Талбайн хэмжээ: 42.0 м ² Суурь: Цутгамал төмөр бетон шугаман Үндсэн хийц: Тоосгон өрөгт бүтээцтэй Гадна хана: Тоосгон өрөгт ханатай, 150 мм-ийн хөөсөнцөр хавтан дулаалга, Хучилт: Цутгамал төмөр бетон Дээвэр: Хавтгай дээвэртэй			
ББ	Хэсгийн дүн:	58,418,659.0	42.0	1,390,920.4
3	в/. Гадна инженерийн шугам сүлжээний ажил: Халаалтын тогоо, бусад тоног төхөөрөмж, холбох хэрэгслийн угсралт Цэвэр усны гүний худаг гаргах Гадна ариутгах татуурга /м/: Хүчтгэсэн хуванцар хоолой Ф110 мм, Ф160 мм Бохир усны цооног /м ³ /: Цутгамал төмөр бетон Гадна цахилгаан /м/: 0.4 кВ-ын кабель шугам 3x50+1x25 мм ² Гадна цахилгаан /м/: 10 кВ-ын агаарын шугам АС Гадна холбоо /м/: Сувагчлалын физик кабель 10 хос	13,371,179.0 15,000,000.0 6,297,801.0 30,894,879.0 2,985,954.0 12,979,064.0 5,570,739.0	1.0 1.0 20.0 30.0 80.0 50.0 110.0	13,371,179.0 15,000,000.0 314,890.0 1,029,829.0 37,324.0 259,581.0 50,643.0
	Хэсгийн дүн:	87,099,616.0		
4	г/. Тоног төхөөрөмж: Тоног төхөөрөмж Хэсгийн дүн:	37,300,000.0		
5	д/. Гадна тохижилтын ажил: Гадна гэрэлтүүлгийн тэжээл /м/: 0.4 кВ-ын кабель шугам 4x16 мм ² Гадна гэрэлтүүлэг /ком/: Нарны зайн хураагууртай Явган зам талбай /м ² /: Өнгөт хавтан хучилттай Авто зам талбай /м ² /: Бетон хучилттай Гадна хашаа /м ² /: Төмөр сараалжин Сандал /ш/:	1,632,000.0 27,277,190.0 31,065,000.0 32,102,265.0 29,291,200.0 3,707,108.0	180.0 12.0 765.0 659.0 294.0 10.0	9,066.7 2,273,099.2 40,607.8 48,713.6 99,629.9 370,710.8

Хогийн сав /ш/:	968,178.0	6.0	161,363.0
Хаягдлын цэг /м²/	4,000,000.0	9.0	444,444.4
Хэсгийн дүн:	130,042,941.0		
6 е/. Зураг төслийн үнэ:			
ЗТУ Зураг төслийн үнэ:	23,750,000.0		
Хэсгийн дүн:	23,750,000.0		
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:			1,925,353,536

Төсөв:

Эксперт нь: Говь-Алтай аймгийн Бугат сумын 5-р багийн нутаг дэвсгэрт баригдах “150 хүний суудалтай соёлын төвийн барилга”-ын ажлын нийт төсөвт өргтийг 1 925 353 536 /нэг тэрбум есөн зуун хорин таван сая гурван зуун тавин гурван мянга таван зуун гучин зургаа/ төгрөгөөр хянажээ.

“Барилгын тухай” Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т “барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх”, 38.1.3-т “зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативийн баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх”, 39.4-т “эксперт барилга байгууламжийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ.”, 39.5-д “Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативийн баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ.”


Тухайн зураг төсөл нь Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын Барилгын зураг төсөлд хяналт хийсэн тухай 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 08 дугаартай дүгнэлтээр хянагдсан байна.

Говь-Алтай аймгийн Бугат сумын 5-р багийн нутаг дэвсгэрт баригдах “150 хүний суудалтай соёлын төвийн барилга”-ын ажлын зураг төсөл, төсөвт “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”, “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНБД 81-94-12/, “Барилгын төсөв зохиох дүрэм” /БНБД 81-95-12/, Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.2.1.52 дугаар хуулийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь экспертуудийн хавсралт 9 хуудас дүгнэлтийн хамт хүчинтэй.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ
ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:**

**БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ**



ЦАМАРСАНАА

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА**



Э.ХАНГАЛ

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН**



М.МАРГАД-ЭРДЭНЭ